



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 20 өдөр

Дугаар A/177

Арвайхээр

### Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2019 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 25 дугаар зөвлөмжийн дагуу Өвөрхангай аймаг дахь Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд 2019 онд хэрэглэгдэх хүнсний бүтээгдэхүүн, шатах тослох материал нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийн 2 дугаар багц мах, махан бүтээгдэхүүнийг 60427000 (жаран сая дөрвөн зуун хорин долоон мянга) төгрөгөөр Багахөгшин ХХК-иар, 3 дугаар багц хүнсний үндсэн бүтээгдэхүүнийг 34277300 (гучин дөрвөн сая хоёр зуун далан долоон мянга гурван зуу) төгрөгөөр Сод-Ээл ХХК-иар 4 дүгээр багц хүнсний туслах бүтээгдэхүүнийг 13015600 (арван гурван сая арван таван мянга зургаан зуу) төгрөгөөр Их-Өшгөг ХХК-иар, 5 дугаар багц шатах, тослох материалыг 63554350 (жаран гурван сая таван зуун тавин дөрвөн мянга гурван зуун тавь) төгрөгөөр Ник ХХК-иар нийлүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Дээрх шалгарсан багцуудад гэрээ байгуулж, бараа нийлүүлэлтийн явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авч гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг Өвөрхангай аймаг дахь Бүсийн оношилгоо, эмчилгээний төв (Э.Хүдэрчулуун)-д зөвшөөрсүгэй.

3. Нэг ч оролцогч үнийн санал ирүүлээгүй 1 дүгээр багц сүү, сүүн бүтээгдэхүүнийг хүчингүй болгосугай.

4. Дээрх хүчингүй болсон багцыг хязгаарлагдмал тендер шалгаруулалтын журмаар дахин зохион байгуулахыг Үнэлгээний хороо (Б.Даваасүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.Содбат

Г.ГАНБОЛД

011100393